



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 10 өдөр

Дугаар /1218

Мандалсан

Циркчдийн III их наадам зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8, 16.1.10, 16.1.12, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөний 3.4.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 15 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дэлгэрхангай сумын уугуул Монгол Улсын Гавьяат жүжигчин, Нэрт алиалагч Д.Батсүхийн нэрэмжит "Цирк байгаа газарт инээд, баяр хөөр" өсвөрийн циркчдийн III их наадмыг Монголын циркчдийн холбоотой хамтран 2017 оны 10 сарын 12-15-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

Хоёр. Циркчдийн III их наадам зохион байгуулах зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. Их наадмын шагналд шаардагдах 2000000 /Хоёр сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ



0000942

